

ТӨВ АЗИ ДАХЬ ОРОСЫН СОНИРХОЛ ЮУ ВЭ?

*К.Дэмбэрэл**

Төв Ази гэсэн ойлголт Каспийн тэнгисээс Дорнод Монголын талыг оруулсан өргөн уудам нутаг. Энэ өргөн уудам нутаг тэр чигээрээ Оросын өмнөд хил. Хил хязгаарын аюулгүй байдлыг сахин хамгаалах, ерөнхийдөө аюулгүй байдлаа бэхжүүлэх гэсэн утгаараа ОХУ-ын хувьд Төв Азийн бүс нутаг стратегийн талаасаа чухал газар. ОХУ-ын хувьд XIX зуунаас бүс нутгийг нөлөөндөө оруулж XX зууны турш “эзэн нь” болж аюулгүй байдлаа бүрэн хангаж чадсан.

Өнөөдөр бүс нутагт ОХУ ямар байр суурьтай байгаа, цаашид хэрхэх талаар явуулах бодлогоос энд өгүүлье.

Төв Азийн талаар баримтлах Оросын гадаад бодлогод 2 асуудал түлхүү яригдах боллоо. Үүнд:

- Аюулгүй байдлын асуудал
- Эрчим хүчний эх үүсвэрийн асуудал

Энэ хоёр асуудал хоорондоо харилцан холбоотой асуудал. Энэ талаар судлаачид олон өнцгөөс нь бичсээр байгаа. Ингээд Төв Азийн эрчим хүчний чадавхи, цаашдын төлөв, Оросын сонирхлын талаархи зарим саналаа нэмэрлэе.

Юуны өмнө, Төв Азийн эрчим хүчний нөөц гэсэн тодорхойлолтод Каспийн тэнгисийн эрэг хавийн орнуудын нөөцийг давхар бодох ёстой. ОХУ нь өөрөө эрчим хүчний их нөөцтэй, дэлхийн тэргүүлэгч тоглогчийн нэг. Гэтэл Төв Азийн эрчим хүчний эх үүсвэрийн асуудлыг анхаарах болсон шалтгаан нь бол зөвхөн урьд нь өөрийн мэдэлд 100% байсан баялаг учраас зүгээр явуулчих сонирхол мэдээж үгүй. Ингээд дэлхийн хэмжээнд асуудал ямар нөхцөл байдалтай байгааг сийрүүлбэл:

Дэлхийн эдийн засгийн хөгжилд нүүрсустөрөгчийн гаралтай түүхий эдийн үүрэг ойрын хагас зуун жилдээ шийдвэрлэх үүрэгтэй хэвээр байх болно. Өндөр хөгжилтэй орнуудын эрчим хүчний аюулгүй байдал нь түүхий эдийн найдвартай, тогтвортой байдлаас л шууд хамаарна. Нефтийн үндсэн хэрэглэгч нь өндөр хөгжилтэй орнууд бөгөөд нийлүүлэгчид нь үндсэндээ шилжилтийн болон хөгжиж буй эдийн засагтай улс орнууд байдаг. Тухайлбал, АНУ нь дэлхийн нефтийн 25,4%-г хэрэглэдэг ба 9,9%-г олборлодог, Зүүн Азийн хөгжилтэй орнууд болох Япон, Өмнөд Солонгос, Тайвань нь олборлодоггүй мөртлөө дэлхийн нефтийн 11%-г хэрэглэдэг, БНХАУ нь дэлхийн нефтийн 4,8%-г олборлодог мөртлөө 8%-г хэрэглэдэг. Зөвхөн энэ хэдэн орнууд л гэхэд 50 орчим хувийг хэрэглэдэг байтлаа 10 гаруй хувийг л олборлож байх жишээтэй. Ойрхи Дорнод дэлхийн нефтийн экспортын 28,5%-г гаргадаг бол дөнгөж 5,9%-г хэрэглэдэг, ОХУ нь 10,7%-г олборлоод 3,5%-г хэрэглэдэг.

Нефть нь тухайн үедээ нүүрсийг шахаж гарч ирсэн бол ойрын ирээдүйд нефтийг байгалийн хий шахах дүр зураг¹ харагдаж байна.

* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Байгалийн хийн олборлолтын хувьд АНУ нь дэлхийн олборлолтын 21,7%-г эзэлдэг мөртлөө 26,3%-н хийг хэрэглэж байгаа. Европын Холбооны 15 улс импортын хийнээс хамааралтай бөгөөд дэлхийн хэрэглээний 15,2%-г эзэлдэг ба 8,3%-г олборлодог. Европын хувьд хийнээс хараат байдал улам л алгуур өсөх хандлагатай байгаа. Зүүн Азийн орнуудын хувьд /Япон, Ө.Солонгос, Тайвань/ шингэрүүлсэн шатдаг хийн импортоос 100% хараат, дэлхийн хийн 4,4%-г хэрэглэдэг. БНХАУ нь олборлосноо хэрэглэдэг байсан бол түүний эдийн засгийн өсөлт нь импортын хийг авахаас өөр аргагүй байдалд хүрч байна.

ОХУ нь дэлхийн хийн экспортын 22%-г гаргадаг ба дотоод хэрэглээ нь 15,3% болж байгаа нь томоохон хэрэглэгч гэдгийн илрэл. Дотоод хэрэглээ, олборлолтын эерүү ийм хэмжээний улс хараахан байхгүй байгаа нь түүнийг энэ салбарын тэргүүлэх улс болгож байгаа юм.

Ойрхи Дорнод байгалийн хийн олборлолт нь 9,3% байж 8,1%-г дотооддоо хэрэглэж байсан, Африкт бага хэмжээний экспортын нөөц байгаа, Ази-номхон далайн орнуудад /Индонез, Малайз, Австрали/ олборлолт 6,2%, хэрэглээ 3,4% байгаа.

Баруун Европ нь нефть, нефтийн бүтээгдэхүүний гол хэрэглэгчдийн нэг бөгөөд ОХУ, ТУХН-ийн орнуудаас 214,6 сая тн, Ойрхи Дорнодоос 161,1 сая тн, Хойд Африкаас 122,5 сая тн-г импортоор авдаг. Европын орнуудын хувьд Африкаас авах нефть бүтээгдэхүүнд АНУ гол өрсөлдөгч болж байгаа. Дэлхийн нефть, нефтийн бүтээгдэхүүний импортын 26%-г /561 сая тн/ АНУ дангаар эзэлдэг ба НАФТА-гаас /Мексик, Канад/ 171,7 сая тн-г, Төв болон Өмнөд Америкаас 119,2 сая тн-г, Африкаас 69,1 сая тн-г, Европоос 57,0 сая тн-г, ОХУ, ТУХН-ийн орнуудаас 9,8 сая тн-г, Ази-номхон далайн орнуудаас 12,8 сая тн, Ойрхи Дорнодоос 114,7 сая тн-г тус тус импортлодог. Энэ байдлаас үзэхэд АНУ эрчим хүчний импортын аюулгүй байдлаа харьцангуйгаар хангаж чадсан төдийгүй өөрөө ч боломжийн нөөцөө хуулиар хамгаалчихсан улс. Шаардлагатай үед хуулиа цуцлаад л олборлоод эхэлнэ. Ойрхи Дорнодын нефть, нефтийн бүтээгдэхүүний экспортын 62,3% нь Ази-номхон далайн орнуудад гардаг. Тухайлбал, Япон бараг 87% хамааралтай байгаа.

Байгалийн хийн хувьд экспортын дүр зураг арай өөр байгаа. Хийг дамжуулах хоолойгоор тээвэрлэж байгаа өнөөгийн нөхцөлд техникийн боломжоос хамаарч бүс нутгийн шинжтэй байгаа.

Далайн тээврийг шингэрүүлсэн шатдаг хийг тээвэрлэхэд ашиглаж байгаа тул нийлүүлэлтэд зохих бэрхшээл байгаа. Дамжуулах хоолойгоор 2002 оны байдлаар 431,35 тэрбум шоо м хийг нийлүүлж байсан бол далайн тээврээр шингэрүүлсэн хийг 150 тэрбум шоо м нийлүүлэгдэж байх жишээтэй.

Япон, Өмнөд Солонгос, Тайвань нь шингэрүүлсэн шатдаг хийн ихэнх буюу 103,8 тэрбум шоо м-г хэрэглэдэг. Баруун Европ 39 тэрбум шоо м, АНУ нь 7,1 тэрбум шоо м. Индонез, Малайз, Австрали нь шингэрүүлсэн шатдаг хийн гол нийлүүлэгчдийн нэг буюу 74 тэрбум шоо м, Алжир, Нигер, Ливи нь 35,35 тэрбум шоо м байгаа.

Хийн хоолойгоор импортлодог улсуудын дотор Баруун Европ тэргүүлдэг бөгөөд 240 тэрбум шоо м, үндсэн нийлүүлэгчид ОХУ 128,2 тэрбум шоо, Алжир 29,38 тэрбум шоо м, 26,13 тэрбум шоо м-г шингэрүүлсэн хэлбэрээр тус тус нийлүүлдэг. АНУ нь хийн хоолойгоор Канадаас 109 тэрбум шоо м-г авдаг. Нефть, хийн зах зээлийн хэрэглээ, нийлүүлэлт тодорхой байгаа нөхцөлд түүний нөөцийн асуудлыг тооцож байх нь хамгийн чухал зүйл билээ.

Дэлхийн хэмжээний нефтийн нийт нөөцийн 65,4% нь Ойрхи Дорнодод байгаа ба одоогийн хэмжээнд олборлоод байвал 92 жил хүрэлцэхүйц байгаа. Хэдий тийм ч энд байгаа улс төрийн нөхцөл байдал харьцангуй тогтворгүй, нийгмийн бүтэц нь төвөгтэй байгаа нь хэрэглэгчдийг давхар эх үүсвэр хайхад хүргэж байна. Өмнөд, Төв Америк нь нөхцөл байдлыг бага ч гэсэн сайжруулах боловч тэр нь зөвхөн АНУ-д хүртээлтэй юм. Африкийн нөөц 30 орчим жил, Зүүн Азийн нөөц 15 жил хүрэлцээтэй байгаа бол ОХУ-ын нөөц 22 жил хэмээн тооцогдож байгаа. Норвеги, Казахстан, Азербайжан зэрэг нэг хүрэхгүй хувь эзэмшдэг нэлээн олон нийлүүлэгчид байгаа нь том асуудал шийдэхэд хангалттай бус. Тиймээс Ойрхи Дорнодын асуудлыг зөв шийдэх нь хамгаас чухал байгаа.

Байгалийн хийн илэрсэн нөөцийн 30 илүү хувь нь ОХУ-д ноогдож байна. Өнөөгийн хурдцаар олборлох тохиолдолд 80 илүү жил ашиглах боломжтой нөөцтэй гэсэн үг. Европын бусад улсууд болон ТУХН-ийн орнуудын нийт нөөц 8,7 хувь байгаагаас Казахстан, Туркмен, Узбекистан улсууд нийлээд дэлхийн нөөцийн 3,7 хувийг эзэмшиж байна. Эдгээрийн нөөц нь ойрын ирээдүйн нийлүүлэлтэд боломжтой ба хэтийн ирээдүйд зөвхөн ОХУ-ын нөөц л дэлхийн хэмжээнд нийлүүлэлтийг үүрэх чадавхитай. Оросын дараа 14,8 хувийн нөөцөөрөө Иран улс орох ба одоогийн олборлолтын хэмжээгээр 100 жилийн нөөцтэй. Катар улс дэлхийн нөөцийн 9,2 хувь, Арабын Нэгдсэн Эмират Улс 3,9 хувь, Саудын Араб Улс 4,1 хувийн нөөцийг тус тус эзэмшдэг.

Африк /Алжир, Нигер, Египет/ 1,7 хувь, Индонез, Малайз нь 1,4 хувийн нөөцтэй. Хойд Америкийн нөөц 4,6 хувь, Өмнөд болон Төв Америкийн нөөц нь 4,5 хувь байгаа. Баруун Европ, Зүүн Ази хоёр хийн эрэлтийн хувьд томоохон өрсөлдөгчид байж нийлүүлэгчид гэсэн ганц зах зээлээс хараат бус байх боломжтой болно.

Дэлхийн зах зээл дээрхи нефть, байгалийн хийн эрэлт нийлүүлэлтийн асуудлаас гадна дэлхийн томоохон үйлдвэрлэгчдийн хоорондын өрсөлдөөн, “салж нийлэх”, монополичлох, үндэсний эрх ашгаа хамгаалах гэсэн үйл явц сүүлийн жилүүдэд эрчтэй явагдаж байгаа. Энэ асуудал өөрөө судалгааны нэг сэдэв төдийгүй эрчим хүчний бодлогыг тодорхойлох нэг хүчин зүйл юм. Европт эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлт илүү хүчтэй байгаа нь нефть, хийн зах зээлд хамгийн нөлөөтэй асуудал болсоор байна. Эцэст нь хэлэхэд, нефть, хийн зах зээлд монополичлох нийлүүлэгч гэсэн цөөн хэдэн улс, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гэсэн супер хэдэн корпораци бий болох хандлага ажиглагдаж байгаа. “Oil and Gas Journal” сэтгүүлийн

мэдээлснээр бол дэлхийн нефть, хийн зах зээлийн 15%-г “супер корпорациуд” хянаж байгаа.

ОХУ нь 2020 он гэхэд байгалийн хийн олборлолтоо 710-730 тэрбум шоо м-т хүргэх төлөвлөгөөтэй байгаа. Байгалийн хийн олборлолт нь ердийн багаар бодоход 2010 онд 635 тэрбум шоо м, харин 2020 он гэхэд 680 тэрбум шоо м-т хүрнэ. Харин Казахстаны хувьд 2015 он гэхэд нефть олборлолт 120-150 сая тн, байгалийн хийн олборлолт 30 тэрбум шоо м-т хүрэх аж.²

Тэрээр ОХУ нь Төв Азийн экспортлогч орнуудад хоёр нөхцөл тулгаж байгаа.

- ОХУ-аар зуучлуулан /дамжуулан/ найдвартай зах зээлтэй байх /зах зээлийн үнээс хямдаар/

- Шууд өрнөдийн зах зээлд өөрсдөө эрсдэлтэй алхам хийж гарах /тэдний санхүүгийн болон бусад дэмжлэг авч/

Байгалийн хийн зах зээлд томоохон хэрэглэгч болох БНХАУ нь /2010 онд гэхэд 180 тэрбум шоо м.куб/ зөвхөн ОХУ-аас хараат байхын эсрэг байгаа тул Төв Азийн улсуудыг энэ байдлыг орлуулагчдын нэг хэмээн үзэж байгаа. Энд Орос, Төв Азийн орнуудын зөрчил гарч ирж байгаа. Хятадын санаа бол Туркмений хийг Хятад руу татахдаа Узбек, Казахын хийг тэр шугаманд холбох төлөвлөгөөтэй байгаа. Байгалийн хийн салбарт Төв Азийн орнуудаас хамгийн том нийлүүлэгч нь Туркмен /жилийн олборлолт нь 70 орчим тэрбум шоо м/. Тэрээр ОХУ-д /1000 шоо м-г 100 ам.долл гэсэн хатуу үнэтэй/ нийлүүлдэг хэдий ч Украин, Иранд нийлүүлэлтээ нэмэгдүүлэх сонирхолтой байгаа.

Төв Азийн хийг ОХУ зуучлан, өөрийн хоолойгоор тээвэрлэх нь түүний Европын Холбооны байгалийн хийн зах зээлд байр сууриа баттай хадгалах ач холбогдолтой зүйл. Ерөнхийдөө, Төв Азийн орнуудаас Ази, Европ чиглэсэн хий нийлүүлэх сонирхол нь ОХУ-ын болон Иран, Азербайжаны эрх ашгийг хөндсөн асуудал болоод байна.

2015 он гэхэд прогнозоор Казах, Узбек, Туркмений хийн олборлолт 150 тэрбум шоо м-т хүрч, түүний нэлээдгүй хэсэг нь Азийн зах зээл рүү чиглэгдэх болно. Гэхдээ өнөөдөр ОХУ-ын нийт олборлолт нь 650 шахам тэрбум шоо м байгаа. Харин Олон улсын эрчим хүчний агентлагийн прогнозоор 2015 он гэхэд Азид нефтийн эрэлт хэрэгцээний өсөлт 800 сая тн хүрэх бол Европт 240 сая тн болох төлөвтэй.

Иймээс Төв Ази нь эрчим хүчний эх үүсвэр, түүнийг дамжуулах хоолойг эзэмшихийн төлөөхи тэмцлийн талбар болж байна. Энэ өрсөлдөөн голлон АНУ, Хятад, ОХУ-ын хооронд явагдаж байна. “Өрсөлдөөн” гэсэн тодотгол нь тэдгээрийн хоорондын хамтын ажиллагааны ямар нэг хэлбэр ажиглагдахгүй байгаад оршино. Энэ байдал нь бүс нутагт хүчээ авч байгаа “исламын экстремистүүдийг” “гааруулахад хүргэж байна” гэсэн дүгнэлтийг зарим судлаачид /М/ хэлж байгаа. Орос-ЗХУ-ОХУ-ын нөлөөний хүрээнд байж ирсэн энэхүү бүс нутагт Америк, Хятадын нөлөө орж ирэхийг ОХУ ямар нэг хэлбэрээр хаах бодлого³ барьсаар байгаа. Энэ нь Оросын нөлөө Төв Азид хүчтэй байгаа гэсэн дүгнэлтийг судлаач Парвиз Муллоджанов

“В геополитике Центральной Азии наступает эпоха всеобъемлющего прагматизма” номондоо хийснийг баталж байгаа хэрэг. Энд нөлөө үзүүлж буй хүчин зүйлийн нэг бол тус бүс нутгийн орнуудын Өрнөд болон ОХУ-ын талыг барьсан улс төрийн бодлого мөн.

Бжезинскийн томъёоллоор “ОХУ нь Төв Ази, Украингүйгээр бол зүгээр нэг улс, харин тэднийг өөрийн нөлөөнд байлгасан цагт эзэнт улс”⁴ гэсэн статустай байх болно. Иймээс энэ бүс нутаг Орост амин чухал газар. Оросууд нь тухайн улсуудын “зөвлөлт системийн бүтээгдэхүүн” болох улс төрийн лидерүүдийг түшсэн бодлого явуулж байгаа. Тиймээс “энэ үе өнгөрөхлөөр” асуудал хааш эргэх нь тодорхой бус байгаа. Оросуудын зүгээс үзүүлж буй тусламж дэмжлэг нь “хүний эрх, ардчиллын үнэт зүйлс” гэсэн хийсвэрлэлд баригдахгүй байгаа нь тухайн бүс нутгийн улс төрийн элитүүдэд нэн таалагдсан зүйлийн нэг. Бүс нутагт даруй шаардлагатай байгаа хөрөнгө оруулалт, эдийн засгийн дэмжлэгийн талаар зохистой бодлого явуулж буй аль ч улстай ямар ч хэлбэрээр хамтран ажиллах сонирхол Төв Азийн орнуудын удирдлагад өнөөгийн нөхцөлд байгаа болно.

Төв Азийн улсуудад энэ цаг мөчид амин чухал нийтлэг асуудал бол эдийн засгийн хувьд өсөн дэвжсэн, улс төрийн хувьд тогтвортой, аюулгүй байдлаа тодорхой хэмжээнд хангасан бие даасан тусгаар улсууд байх явдал.

Төв Азид бий болсон “Большой Центральной Азии”, “Центра Евразийского Союза”, “Центральноазиатского экономического союза” зэрэг хамтын ажиллагааны хэлбэрүүд нь үр багатай, тухайн байгууллагад хэн нөлөөтэй нь бусдыгаа өөртөө татах арга механизм болоод байгаа.

Судлаач Б.Бешимов “Кто рисует картину новой геополитики в Центральной Азии?” номондоо Төв Азийн орнуудын хувьд “амин чухал” болох 3 гол асуудлын нэг бол бүс нутгийн улсуудын, түүний дотроос ОХУ-тай нөхөрсөг, сайн хөршийн харилцаатай байх явдал хэмээн тодорхойлсон байна. Тэрээр өнгөрсөн 20 шахам жилд зайлшгүй чухал зүйл гэдэг нь батлагдсан аж. Түүнчлэн, бүс нутагт голлох байр суурийн төлөө, ундны усны төлөө, газар нутгийн төлөө, үндэстэн угсаатны зөрчил, зарим улсуудын төвийг сахисан байр суурь зэрэг нь бүс нутгийн улсуудын интеграцид муугаар нөлөөлж буй хүчин зүйлүүд хэмээн бичсэн.

М.Н.Омаров “Н” өгүүлэлдээ: ОХУ нь аль 1995 оны 02 сарын 14-нд Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан “Об утверждении стратегического курса РФ с государствами-участниками СНГ” гэсэн баримт бичгийг үндэслэн ТУХН-ийн орнуудтай, тухайлбал, Төв Азийн улсуудтай хамтын ажиллагааг явуулж байгаа нь цаг үеэс хэт хоцрогдсон, үйл явцтай дэндүү нийцэхгүй зүйл байгаа хэмээн шүүмжилсэн. Тиймээс хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг тусгасан баримт бичгийг боловсруулан мөрдөхийг чухалчилсан. Өөрөөр хэлбэл, ОХУ-ын зүгээс Төв Азид баримтлах улс төрийн бодлого тодорхой бус, стратеги алга гэсэн дүгнэлт хийсэн. Дотоод улс төр, эдийн засгийн асуудал, бүс нутаг дахь тодорхой бус ойр зуурын арга хэмжээ, өнөө маргаашийн асуудал зэрэг нь ОХУ-ыг энэ бүс нутагт зохих хэмжээний цэрэг зэвсгийг байлгаж байх хуучин “зөвлөлт”

сэтгэлгээнээс салгахгүй байгаа. Хэрвээ эдийн засаг, улс төрийн дорвитой арга хэмжээ авч шинэ байр сууринаас хандах илүү хямд, үр ашигтай бодлогоос цэрэг зэвсэг барьж байхыг Оросууд илүүд үзэж байгаа.

Тажик улсад цэрэг зэвсгээ хадгалсаар байгаа нь түүнийг боломжтой үед бүс нутагт хямд зардлаар нөлөөгөө сэргээх, хадгалах нөхцлийг бүрдүүлж байна. Түүнчлэн, бүс нутагт эрчим хүчний эх үүсвэрийг хянах, тээвэрлэх асуудлыг барьж байх нөхцөл болно.

ОХУ нь Төв Азид явуулах улс төр, эдийн засгийн бодлогын өнөөгийн бааз суурь нь ТУХН гэсэн холбоо болж байна. Энэ холбоо нь хуучин зөвлөлтийн үед бий болсон эдийн засаг, соёлын бүтцийг таслахгүйгээр үргэлжлүүлэх шилжилтийн үеийн систем /бүтэц/ болж чадсан.

Сүүлийн 10 шахам жилд дэлхийн эрчим хүчний систем тогтворгүй байдалтай байгаа. Олборлолтын байдал харьцангуй төвөгтэй болж, өөрийн өртөг болон нийлүүлэлтийн системд гажуудал гарсан. Эрэлт хэрэгцээ огцом нэмэгдсэн, тээвэрлэлтийн систем өөрчлөлт хийгдэх шаардлага гарсан. Энд зөвхөн нефтийн асуудал ч биш байгалийн хий, нүүрсний асуудал давхар босч ирсэн. Ихэнхи улсууд эрчим хүчний аюулгүй байдалдаа эргэлзэх болсон. Үнийн өсөлт нь зарим экспортлогч орнуудыг тухайн салбарт хөрөнгө оруулалт хийх хэтийн төлөвийг харагдуулсан ч, үнийн уналт нь дахиад л эргэлзээнд хүргэсэн. Хөгжингүй орнуудын эрэлт, хэрэгцээ үндсэндээ зохицуулагдсан ба хөгжиж буй Хятад, Энэтхэг зэрэг орнуудын хэрэгцээ шинээр өсөн нэмэгдэж буй нь эрчим хүчний зах зээлд мэдэгдэхүйц “хөдөлгөөн” оруулж байна. Тэдгээр орнууд 2030 он гэхэд нийт хэрэглэх нефтийн 75-аас доошгүй хувийг импортоор⁵ хангана. Тиймээс тэд шууд нийлүүлэгч нартай харилцаа холбоогоо нэмэгдүүлж, найдвартай талаа баримтлах болсон. Энэ утгаараа Хятад, Энэтхэг улсууд Төв Ази, Африк руу хүчтэй хандах болсон.

Оросуудын хувьд Төв Азид өрнөдийн оролцоог таатай хүлээж авахгүй байгаа. Гэхдээ тэнд исламын экстремизм хүчээ авахыг бүр ч үзэхгүй байгаа. Ялангуяа, энэхүү сөрөг үзэгдэл Казахстанд нөлөөлбөөс ОХУ-ын хувьд шууд заналхийлалтэй ялгаагүй зүйл. Төв Ази дахь 200 гаруй жилийн Оросын нөлөөг эергээр авч үздэг нь өнөөгийн ОХУ-ын бүс нутагт нөлөөгөө хадгалсаар байх бодит хүчин зүйлийн нэг мөн. Энд зөвхөн газарзүйн талаасаа ч биш юм. Зарим нөлөө бүхий улс төрчид, улс төрийн хүчний үзэж буйгаар бол Зөвлөлтийн үеийн Дундад Ази дахь нөлөө, үйл ажиллагаа нь бүс нутгийн хувьд “сэргэн мандлын үе” байсан гэсэн тодорхойлолт өгдөг.

ОХУ-ын эдийн засгийн өсөлтөөс Төв Азийн бүс нутаг дахь түүний нөлөөний өсөлт хамаарна. Түүнчлэн, Оросын зах зээл Төв Азийн орнуудад өрнөдийн зах зээлийг бодвол илүү нээлттэй байгаа. Зөвлөлтийн орон зайг Өрнөдөөр нөхөх гэсэн гэнэн бодолтой цаг үе байсан хэмээн зарим “удирдагчид” нь хүлээн зөвшөөрсөн тал ч бий. Төв Азийн орнуудтай ОХУ-ын нэгдэн орсон хамтын ажиллагааны бүтцүүдийн үйл ажиллагаанаас үл хамаарч тэнд Оросын байр нэмэгдсэн ба хэрвээ тухайн чиглэлд үйл ажиллагаа идэвхжвээс улам нэмэгдэх нь тодорхой. Тухайлбал, ААХГБ, ШХАБ, ЕАЭЗХА гэх мэт. Төв Азийн орнуудын зорилго бол Оросын нөлөөг

хадгалахдаа өнөөгийн тусгаар тогтнолын байр сууриа дэлхий дахинд улам мэдрүүлж, эдийн засгийн хувьд харьцангуй бие даах явдал. Түүний зэрэгцээ АНУ, БНХАУ-ын сонирхлыг зохих түвшинд оруулах далд санаагаа ч илэрхий тавьж байгаа.

АНУ-ын цэргийн баазыг Узбек, Кыргызд байрлуулсан явдал тухайн улсуудын ардчилал, эрх чөлөөг эрхэмлэсэн америкийн эрх ашгийг оруулсан явдал бус энэхүү үйл ажиллагаанаас тухайн улсын төсөвт орж ирдэг мөнгө нь чухал байсан. Бүс нутагт Оросын ч, өрнөдийн сонирхол эдийн засгийн үүднээс зөрчилтэй байгаа буюу хэтдээ зөрчилдөх нь маргаангүй асуудал. АНУ болон өрнөдийн тусламж дэмжлэг нь бүс нутгийг эдийн засгийн хувьд өөрчлөн босгох хэмжээнд байж, улс төр соёлын довтолгоог аль болох хязгаарлан аажим татах бодлого шаардлагатай байгаа. Цэргийн баазын түрээсийн төлбөр, бага хэмжээний хөрөнгө оруулалтаар бүс нутагт нөлөө бий болгох асуудал шийдэгдэхгүй.

Аль ч улсын хувьд Төв Азид явуулах бодлого, стратегитээ бүс нутагт өсөн нэмэгдэж буй эдийн засаг, улс төр, цэрэг-стратегийн томоохон “ялгарал” төдийгүй Оросын бий болгосон сонирхолтой зөрчилдөх нь гэдгийг бодолцох ёстой. Хамгийн ноцтой зүйл бол өнөөгийн “янз бүрээр” хэлэгдэж буй улс төрийн дэглэм унаж хэт үндсэрхэг, шашны, бүлэглэлийн дэглэм гарч ирэн улс хоорондын мөргөлдөөн бий болох аюул нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг.

Аливаа нэгэн улс дангаар эрх ашгаа илүү байлгах нөхцөл бүрдэхгүй учраас сонирхол гаргаж буй улсууд үйл ажиллагаа, бодлогоо илүү нээлттэй байлгаж, тодорхой болгох нь бүгдийн эрх ашигт нийцнэ. Нэн ялангуяа, ОХУ, АНУ нь бүс нутагт шинэ эдийн засгийг бий болгох /эдийн засгийн том төсөл дээр/ тал дээр илүү ойртож, терроризмын эсрэг үйл ажиллагаандаа хамтран оролцох илүү зохистой үйлдэл. Бүс нутагт Орос-Хятадын үр ашигтай хамтын ажиллагаа 3 дахь хүчнийг ямар хэмжээнд байлгах тал дээр чухал хүчин зүйл байх нь гарцаагүй. ОХУ нь Төв Азид илүү прагматик бодлого явуулах нь түүний байр суурийг бэхжүүлэх, нэр төрийг өсгөх, урт хугацааны хамтын ажиллагааны эхлэл болно. Нэн ялангуяа, аюулгүй байдал, эрчим хүчний салбар, хүний эрхийн асуудал дээр онцгой анхаарч байх нь зүйтэй.

Бүс нутагт ОХУ-ын оролцоотойгоор нэгэнт буй болсон бүтцийг улам идэвхжүүлэх, үр ашигтай байнгын ажиллагаатай механизм болгох тал дээр үйл ажиллагаагаа түлхүү явуулах нь эдийн засгийн хувьд ч, улс төрийн хувьд ч өгөөжтэй.

ШХАБ (ШОС), Евразийн ЭЗХАБ (ЕврАзЭС), Терроризмын эсрэг төв (АТЦ), Төв Азийн Хамтын Ажиллагааны Байгууллага (ОЦАС), Аюулгүй байдлын Аюулгүй ажиллагааны хамтын гэрээний байгууллага (ОДКБ0, Төв Азийн хамтын ажиллагааны байгууллага (ЦАС) зэрэг бүтэц бүрт ОХУ-ын нөлөө мэдэгдэхүйц байгаа нь эдгээрийн үйл ажиллагааг идэвхжүүлэн ашиглах нь бүс нутагт түүний нөлөө эрс нэмэгдүүлэх хялбар боломж юм. Түүнээс гадна бүс нутгийн бүх улсуудтай стратегийн түншлэлийн гэрээтэй байгаа.

ОХУ-ын хувьд Төв Азид явуулах бодлогодоо улс төр, эдийн засгийн механизмыг ашиглахаас гадна Өрнөдөд аль эрт бий болсон механизмуудыг бий болгон ашиглах чухал бөгөөд шинэлэг зүйл болно. ОХУ-ын Төв Азид явуулах бодлогын үр дүн нь түүний үр ашигтай байдал, хамтын эрх ашгийг хэр оруулсан, хэр өгөөжтэй байх, улс бүрийн эмзэг асуудлыг хэр шийдэж байгаа зэргээс шууд хамаарна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Д.Ергина и М.Стоппарда. “Россия в глобальной политике, т. 1, №4, окт.–дек. 2003”
2. Н.А.Симония. Энергобезопасность Запада и роль России. “Россия в глобальной политике”. №2, Март - Апрель 2004
3. Р.Жумалы: “Геополитика Центральной Азии. О былом и насущном”
4. З.Бжезински. Шатрын аварга хөлөг. УБ., 2003.
5. Дэвид Виктор и Линда Юэ: Россия в глобальной политике “Том 8” №1 Январь – февраль - 2010 с. 168